



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 5/08

Хэрлэн сум

Баянмөнх сумын Засаг даргыг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоолын 1, Засгийн газрын 2014 оны 333 дугаар тогтоолын "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" 333 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёрдугаар хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн санал авсан, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5, 26.5.1, 26.5.2, 26.5.3, 26.5.4, 26.5.5 дахь заалтад заасан шаардлагыг хангасан Мижидийн Цэнгэлийг Баянмөнх сумын Засаг даргаар томилсугай.

Хоёр. Сумын Засаг дарга М.Цэнгэлийн үндсэн цалинг 720257 /долоон зуун хорин мянга хоёр зуун тавин долоон/ төгрөгөөр, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын цалингийн 30 хувиар тооцож цалинжуулахыг Баянмөнх сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 013